



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОДОН ОРОН, ГЕОФИЗИКИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/49/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjbyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 261740 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/417
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>176,851,520.19</u>	<u>221,121,060.81</u>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	97,123,978.00	81,039,179.99
3121	Төгрөг	97,123,978.00	81,039,179.99
31213	Арилжааны банк дахь харилцах	97,123,978.00	81,039,179.99
33	АВЛАГА	43,136,338.06	24,702,165.44
33300	Татаас, санхүүжилтийн авлага	43,136,338.06	24,702,165.44
34	УРЬДЧИЛГАА	00.00	52,059,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	00.00	52,059,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	00.00	52,059,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,591,204.13	63,320,715.38
351	Түүхий эд материал	36,591,204.13	60,970,715.38
35110	Тусгай зориулалттай материал	36,591,204.13	60,970,715.38
354	Хангамжийн материал	00.00	2,350,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	2,350,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,464,603,433.57</u>	<u>7,071,371,733.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,464,603,433.57	7,071,371,733.13
392	Биет хөрөнгө	5,426,606,348.32	5,425,445,678.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,620,954,387.53	3,692,799,257.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(320,560,115.72)	(431,275,971.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,000,000.00	127,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(34,849,166.77)	(53,389,166.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,701,508,329.37	3,348,136,156.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,714,978,576.87)	(1,307,786,463.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129,404,842.12	118,573,797.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(85,640,916.55)	(72,379,495.11)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,300,000.00	1,300,000.00
39217	Ном	2,467,565.21	2,467,565.21
393	Биет бус хөрөнгө	1,037,997,085.25	1,645,926,054.18
39301	Програм хангамж	632,770,571.57	632,770,571.57
39302	Хуримтлагдсан элэгдэл	(373,463,086.32)	(436,994,117.39)
39303	Бусад биет бус хөрөнгө	778,689,600.00	1,450,149,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,641,454,953.76</u>	<u>7,292,492,793.94</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,400,000.00</u>	<u>7,114,999.75</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,400,000.00	7,114,999.75
413	Өглөг	6,400,000.00	7,114,999.75
4136	Бусад өглөг	6,400,000.00	7,114,999.75
41361	Байгууллагад төлөх өглөг	6,400,000.00	3,500,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	3,614,999.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,635,054,953.76</u>	<u>7,285,377,794.19</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,885,473,985.31	3,885,473,985.31
511	Засгийн газрын оруулсан капитал	2,889,184,696.66	2,889,184,696.66
51101	Өмч: - төрийн	2,889,184,696.66	2,889,184,696.66
512	Хуримтлагдсан үр дүн	2,749,580,968.45	3,399,903,808.88
51210	Өмнөх үеийн үр дүн	1,366,363,332.69	2,749,580,968.45
51220	Тайлант үеийн үр дүн	1,383,217,635.76	650,322,840.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	996,289,288.65	996,289,288.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,641,454,953.76</u>	<u>7,292,492,793.94</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,905,336,275.57	7,777,608,540.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,759,087,120.88	3,620,413,457.22
120	Нийтлэг татварын бус орлого	1,674,373,892.88	1,150,744,191.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,660,482,322.88	1,150,744,191.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,660,482,322.88	1,150,744,191.00
122	Тусламжийн орлого	2,084,713,228.00	2,469,669,266.22
122002	Хандив тусламж /гадаад/	2,084,713,228.00	2,469,669,266.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,146,249,154.69	4,157,195,082.97
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,833,310,800.00	3,952,742,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,833,310,800.00	3,952,742,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	312,938,354.69	204,452,882.97
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,636,175.00	75,025,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250,302,179.69	129,427,882.97
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,522,118,639.81	7,127,285,699.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,522,118,639.81	7,127,285,699.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,264,854,587.55	6,852,499,337.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,299,923,317.44	2,246,936,321.43
210101	Үндсэн цалин	1,784,713,197.97	1,730,866,932.35
210102	Нэмэгдэл	252,187,320.00	260,774,392.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,796,400.00	220,951,716.97
210105	Гэрээт ажлын хөлс	33,226,399.47	34,343,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	290,427,771.92	295,744,897.79
210201	Тэтгэврийн даатгал	200,126,821.50	207,932,184.06
210202	Тэтгэмжийн даатгал	22,705,405.01	22,683,300.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,200,954.95	17,689,751.07
210204	Ажилгүйдлийн даатгал	5,094,356.99	4,460,778.04
210205	Эрүүл мэндийн даатгал	45,300,233.47	42,978,884.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,432,849.36	217,318,324.94
210301	Гэрэл, цахилгаан	154,780,597.35	151,326,280.78
210302	Түлш, халаалт	46,654,644.61	57,858,250.62
210303	Цэвэр, бохир ус	7,997,607.40	8,133,793.54
2104	Хангамж, бараа материалын зардал	73,620,884.61	68,523,981.60
210401	Бичиг хэрэг	4,176,341.60	2,486,590.00
210402	Тээвэр, шатахуун	11,165,510.00	9,268,847.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,402,354.01	32,661,775.43
210404	Ном, хэвлэл	7,249,075.00	463,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	971,000.00	446,128.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,656,604.00	23,197,641.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	124,039,885.25	83,798,128.65
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,992,513.65	55,462,028.65

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	4,454,700.00
210604	Урсгал засвар	80,047,371.60	23,881,400.00
2107	Томилолт, зочны зардал	129,343,970.63	80,173,959.68
210702	Дотоод албан томилолт	129,343,970.63	80,173,959.68
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	624,136,726.28	612,081,602.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	585,298,001.28	604,411,729.55
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,400,000.00	3,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	582,462.00	488,190.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	478,912.00	599,337.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	121,000.00
210807	Газрын төлбөр	31,267,351.00	2,961,346.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,513,929,182.06	3,247,922,120.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,837,629,305.00	2,367,478,114.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,008,000.00	10,216,068.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	675,291,877.06	870,227,938.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	257,264,052.26	274,786,362.35
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,642,131.00	4,644,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,642,131.00	4,644,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,215,000.00	18,079,456.75
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	13,614,999.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,215,000.00	4,464,457.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	248,406,921.26	252,062,905.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	247,855,615.77	251,950,669.60
113305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	551,305.49	112,236.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	<u>1,383,217,635.76</u>	<u>650,322,840.43</u>
5	НИЙТ ҮР ДҮН	<u>1,383,217,635.76</u>	<u>650,322,840.43</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,889,184,696.66	996,289,288.65	1,366,363,332.69	5,251,837,318.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,889,184,696.66	996,289,288.65	1,366,363,332.69	1,366,363,332.69
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,383,217,635.76	1,383,217,635.76
D01	2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,889,184,696.66	996,289,288.65	2,749,580,968.45	6,635,054,953.76
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,889,184,696.66	996,289,288.65	2,749,580,968.45	6,635,054,953.76
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	650,322,840.43	650,322,840.43
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,889,184,696.66	996,289,288.65	3,399,903,808.88	7,285,377,794.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>6,230,962,382.69</u>	<u>6,670,000,687.25</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,084,713,228.00	2,469,669,266.22
122	Тусламжийн орлого	2,084,713,228.00	2,469,669,266.22
122002	Хандив тусламж /гадаад/	2,084,713,228.00	2,469,669,266.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,146,249,154.69	4,200,331,421.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,833,310,800.00	3,952,742,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,833,310,800.00	3,952,742,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	312,938,354.69	247,589,221.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,636,175.00	75,025,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250,302,179.69	172,564,221.03
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>5,882,052,409.69</u>	<u>6,359,833,438.16</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,882,052,409.69	6,359,833,438.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,581,652,019.37	6,063,959,910.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,299,923,317.44	2,246,936,321.43
210101	Үндсэн цалин	1,784,713,197.97	1,730,866,932.35
210102	Нэмэгдэл	252,187,320.00	260,774,392.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,796,400.00	220,951,716.97
210105	Гэрээт ажлын хөлс	33,226,399.47	34,343,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	290,411,992.40	295,744,897.79
210201	Тэтгэврийн даатгал	200,111,041.98	207,932,184.06
210202	Тэтгэмжийн даатгал	22,705,405.01	22,683,300.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,200,954.95	17,689,751.07
210204	Ажилгүйдлийн даатгал	5,094,356.99	4,460,778.04
210205	Эрүүл мэндийн даатгал	45,300,233.47	42,978,884.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,432,849.36	217,318,324.94
210301	Гэрэл, цахилгаан	154,780,597.35	151,326,280.78
210302	Түлш, халаалт	46,654,644.61	57,858,250.62
210303	Цэвэр, бохир ус	7,997,607.40	8,133,793.54
2104	Хангамж, бараа материалын зардал	72,125,973.01	68,523,981.60
210401	Бичиг хэрэг	3,734,800.00	2,486,590.00
210402	Тээвэр, шатахуун	11,165,510.00	9,268,847.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,402,354.01	32,661,775.43
210404	Ном, хэвлэл	7,249,075.00	463,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	971,000.00	446,128.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,603,234.00	23,197,641.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	124,039,885.25	156,791,829.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,992,513.65	128,455,729.90
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	4,454,700.00
210604	Урсгал засвар	80,047,371.60	23,881,400.00

2107	Томилолт, зочны зардал	129,343,970.63	80,173,959.68
210702	Дотоод албан томилолт	129,343,970.63	80,173,959.68
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	617,736,726.28	614,981,602.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	585,298,001.28	604,411,729.55
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		6,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	582,462.00	488,190.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	478,912.00	599,337.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	121,000.00
210807	Газрын төлбөр	31,267,351.00	2,961,346.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,838,637,305.00	2,383,488,992.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,837,629,305.00	2,373,272,924.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,008,000.00	10,216,068.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,400,390.32	295,873,528.04
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,642,131.00	4,644,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,642,131.00	4,644,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,215,000.00	14,464,457.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,215,000.00	4,464,457.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	291,543,259.32	276,765,071.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	247,855,615.77	251,950,669.60
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	43,687,643.55	24,814,401.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>348,909,973.00</u>	<u>310,167,249.09</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	251,785,995.00	326,252,047.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	251,785,995.00	326,252,047.10
2200	Дотоод эх үүсвэрээр	251,785,995.00	326,252,047.10
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	251,785,995.00	326,252,047.10
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(251,785,995.00)</u>	<u>(326,252,047.10)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	97,123,978.00	(16,084,798.01)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	97,123,978.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,123,978.00	81,039,179.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	93.6
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,952,742,200.00	3,700,791,530.40	251,950,669.60	93.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,952,742,200.00	3,700,791,530.40	251,950,669.60	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,933,473,800.00	3,681,683,073.40	251,790,726.60	93.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,370,903,400.00	2,212,593,041.43	158,310,358.57	97.6
210101	Үндсэн цалин	1,774,247,400.00	1,730,866,932.35	43,380,467.65	86.6
210102	Нэмэгдэл	300,976,000.00	260,774,392.11	40,201,607.89	74.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	295,680,000.00	220,951,716.97	74,728,283.03	86.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	336,082,900.00	291,429,447.79	44,653,452.21	86.1
210201	Тэтгэврийн даатгал	236,502,800.00	203,616,734.06	32,886,065.94	91.1
210202	Тэтгэмжийн даатгал	24,895,000.00	22,683,300.42	2,211,699.58	88.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,916,000.00	17,689,751.07	2,226,248.93	89.6
210204	Ажилгүйдлийн даатгал	4,979,000.00	4,460,778.04	518,221.96	86.3
210205	Эрүүл мэндийн даатгал	49,790,100.00	42,978,884.20	6,811,215.80	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	208,220,400.00	208,010,024.94	210,375.06	28.0
210301	Гэрэл, цахилгаан	110,926,600.00	142,017,980.78	(31,091,380.78)	64.9
210302	Түлш, халаалт	89,160,000.00	57,858,250.62	31,301,749.38	100.0
210303	Цэвэр, бохир ус	8,133,800.00	8,133,793.54	6.46	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,379,500.00	45,375,675.63	3,824.37	107.0
210401	Бичиг хэрэг	2,324,600.00	2,486,590.00	(161,990.00)	71.1
210402	Тээвэр, шатахуун	7,266,500.00	5,168,847.00	2,097,653.00	112.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,737,000.00	25,559,842.63	(2,822,842.63)	9.8
210404	Ном, хэвлэл	4,737,100.00	463,000.00	4,274,100.00	35.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,260,300.00	446,128.00	814,172.00	159.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,054,000.00	11,251,268.00	(4,197,268.00)	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	324,858,200.00	324,640,427.00	217,773.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	233,453,600.00	233,448,987.00	4,613.00	96.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,600,000.00	4,454,700.00	145,300.00	99.9
210604	Урсгал засвар	86,804,600.00	86,736,740.00	67,860.00	97.4
2107	Томилолт, зочны зардал	48,226,800.00	46,955,985.00	1,270,815.00	97.4
210702	Дотоод албан томилолт	48,226,800.00	46,955,985.00	1,270,815.00	92.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	589,126,800.00	542,462,403.61	46,664,396.39	97.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	546,913,700.00	531,892,530.61	15,021,169.39	49.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,000,000.00	6,400,000.00	6,600,000.00	67.6
210803	Даатгалын үйлчилгээ	722,500.00	488,190.00	234,310.00	92.5

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	647,600.00	599,337.00	48,263.00	84.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	121,000.00	22,000.00	10.7
210807	Газрын төлбөр	27,700,000.00	2,961,346.00	24,738,654.00	95.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,675,800.00	10,216,068.00	459,732.00	95.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,675,800.00	10,216,068.00	459,732.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,644,000.00	4,644,000.00	0.00	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,644,000.00	4,644,000.00	0.00	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,644,000.00	4,644,000.00	0.00	98.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,624,400.00	14,464,457.00	159,943.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,000,000.00	10,000,000.00	0.00	96.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,624,400.00	4,464,457.00	159,943.00	93.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,952,742,200.00	3,700,791,530.40	251,950,669.60	93.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,952,742,200.00	3,700,791,530.40	251,950,669.60	93.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,952,742,200.00	3,700,791,530.40	251,950,669.60	93.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	200	200	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	145	145	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	54	54	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		247,589,221.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ		247,589,221.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		222,774,819.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		34,343,280.00
210105	Гэрээт ажлын хөлс		34,343,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,315,450.00
210201	Тэтгэврийн даатгал		4,315,450.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,308,300.00
210301	Гэрэл, цахилгаан		9,308,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал		23,148,305.97
210402	Тээвэр, шатахуун		4,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,101,932.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		11,946,373.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		30,884,780.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		29,824,780.00
210604	Урсгал засвар		1,060,000.00
2107	Томилолт, зочны зардал		33,217,974.68
210702	Дотоод албан томилолт		33,217,974.68
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		87,556,728.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		87,556,728.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		24,814,401.44
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		24,814,401.44
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		24,814,401.44
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		247,589,221.03
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		247,589,221.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		75,025,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		172,564,221.03

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлэн гэрээт ажлын цалин хөлс олгосонтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 28-наас 2022 оны 2 дугаар сарын 23-ны хооронд Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Долгоржав гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Одон орон, геофизикийн хүрээлэн одон орон, сансар судлал, геофизик, газар хөдлөл судлалын чиглэлээр онолын суурь судалгаа, судалгаа боловсруулалтын ажлыг орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн түвшинд гүйцэтгэх, судалгааны үр дүн, шинэ мэдлэг мэдээллээр дэлхийн шинжлэх ухааны сан хөмрөгт хувь нэмрээ оруулах, нийгэмд шинэ мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх цогц үйл ажиллагааг эрхэлдэг Боловсрол, Шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний Шинжлэх ухааны академийн харьяа байгууллага байна.

Тус хүрээлэн астрометр, астрофизик, соронзон орны болон газар хөдлөлийн судлалд монгол орны газарзүйн байрлал, ажиглалт хэмжилт хийх таатай давуу нөхцлийг ашиглан сансар огторгуйн уудам, дэлхийн гүн болон геомандалд болж буй үзэгдэл, хувьсал өөрчлөлтийн процессийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, одон орон, сансар судлал, геофизик, газар хөдлөл судлалын чиглэлээр суурь судалгааг гүйцэтгэдэг байна. Үүнд:

- Астрометр судлал
- Астрофизик судлал
- Астропарк үйл ажиллагаа
- Соронзон судлал
- Газар хөдлөл судлал

Хүрээлэн нь хэрэгжүүлж буй судалгаа шинжилгээ, одон орон судлах оргил, соронзон орон судлал, астропарк, орон нутаг дахь газар хөдлөлтийг бүртгэх 12 станцуудын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд захиргаа, санхүү, аж ахуйг удирдан чиглүүлж, төсвийн эд хөрөнгө,

санхүүжилтийг хууль журмын дагуу үр ашигтай, оновчтой зарцуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ.

Одон орон, геофизикийн хүрээлэнд хянан шалгах бүтэц, зохион байгуулалтгүй ба 2021 онд дээд шатны байгууллагууд болон хяналт, шалгалтын байгууллагуудаас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,127,285.7 мянган төгрөгөөс 1.0 хувь буюу 71,272.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,389,617.6

мянган төгрөгөөр буюу 26 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	97,124.0	81,039.2	-16,084.8
Авлага	43,136.3	24,702.2	18,434.1
Урьдчилгаа	0.0	52,059.0	52,059.0
Бараа материал	36,591.2	63,320.7	26,729.5
Үндсэн хөрөнгө	6,464,603.4	7,071,371.7	606,768.3
Нийт хөрөнгө	<u>6,641,454.9</u>	<u>7,292,492.8</u>	<u>651,037.9</u>
Өр төлбөр	6,400.0	7,115.0	715.0
Цэвэр хөрөнгө/өмч	6,635,065.0	7,285,377.8	650,312.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>6,641,465.0</u>	<u>7,292,492.8</u>	<u>651,027.8</u>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 16,084.8 мянган төгрөг нь 2 улсын Засгийн газрын хоорондын гэрээний төслийн үлдэгдэл;
- Авлагын дансны оны эцсийн үлдэгдэл 24,702.2 мянган төгрөг өмнөх оны эцсийн үлдэгдлээс 18,434.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь татаас санхүүжилтийн авлага бөгөөд нэмэлт санхүүжилтийн хөрөнгөөс зарцуулагдаагүй 24,702.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн;
- Урьдчилгаа дансан дахь оны эцсийн үлдэгдэл 52,059.0 мянган төгрөг нь үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотойгоор урьдчилж гарсан;
- Бараа материалын эцсийн үлдэгдэл 63,320.7 мянган төгрөг өмнөх оны эцсийн үлдэгдлээс 26,729.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 206,899.1 мянга, өөрийн хөрөнгөөр 227,344.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, зарцуулсан;
- Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 9,373,196.9 мянган төгрөг өмнөх оны эцсийн үлдэгдлээс 379,101.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 213,770.9 мянган, хандив тусламжийн 112,481.1 мянган, ТӨБЗГ-ын 2021 оны 706 дугаар тогтоолоор 1,150.744.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч нийт 1,476,996.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. ТӨБЗГ-ын 2021 оны №А-2/1421 тоот албан бичиг, 624, 706 дугаар тогтоолоор нийт 1,097,894.6 мянган төгрөгийн хөрөнгүүдийг данснаас хасчээ. Тайлант онд 870,227.9 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардал бүртгэсэн байна.
- Өр төлбөр данс эцсийн үлдэгдэл 7,115.0 мянган төгрөг болж, өмнөх оны эцсийн үлдэгдлээс 7,115.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь онд аудит батлгаажуулалт зэрэглэл тогтоох болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн хөрөнгийг дутуу батлуулснаас шалтгаалан өглөг үүсчээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх орлого өмнөх оны үзүүлэлтээс гадаад хандив тусламж 384,956.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ч, үнэ төлбөргүй хүлээн авах орлого багассантай холбоотойгоор нийт орлого 127,727.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 605,167.1 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газар хоорондын гэрээгээр гүйцэтгэх бараа ажил үйлчилгээний зардал нь өмнөх оноос 733,993.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

6.3.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,643,541.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,643,541.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 690,798.8 мянган төгрөгөөр бууруулж, 3,952,742.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төслийн саналд тусгасан зардлуудаас урсгал засвар 328,488.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 149,042.4 мянга, гэрэл, цахилгаан 87,350.2 мянга, үндсэн цалин 82,616.9 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 39,375.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 3,952,742.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,952,742.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	код	нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи	3,952,742.2	3,700,791.5	251,950.7	93.6
2	80101	Үндсэн үйл ажиллагаа	3,422,706.6	3,185,936.1	236,770.5	93.1
3	80219	Харуул, хамгаалалтын зардал	232,800.0	217,779.8	15,020.2	93.5
4	80220	Холбооны суваг ашигласны хөлс	277,967.2	277,967.2	0.0	100.0
5	80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	4,644.0	4,644.0	0.0	100.0
6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	14,624.4	14,464.5	159.9	98.9

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,700,791.5 мянган төгрөг буюу 93.6 хувьтай байгаа нь цалин өндөр насны чөлөөнд гарсан, гадаадад суралцахаар явсан, жирэмсний амралт, хүүхдээ асрах чөлөө авсан зэргээс шалтгаалж 44,653.4 мянган; цар тахалт өвчний улмаас хээрийн станцын ажил зогссоноос бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 46,664.4 мянган; томилолтын 1,270.8 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд газар хөдлөл болон түүний аюулыг нарийвчлан тодорхойлох ажлуудаас 172,564.2 мянган, БШУЯ, ШУТС-ийн захилгат нэр бүхий 8 судалгаа, төслийн санхүүжилтээр 75,025.0 мянган буюу нийт 247,589.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа ажил үйлчилгээний зардалд 222,774.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 24,814.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд боловсрол шинжлэх ухааны салбарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 хөтөлбөрийн 37 арга хэмжээний хэрэгжилт 93.1 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд нийт 3,952,742.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 3,700,791.5 мянган төгрөг зарцуулж 93.6 хувийн биелэлттэй, 6.4 хувь буюу 251,950.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь нэмэлт санхүүжилтийн хүрээнд гадаад болон дотоодын төслийн санхүүжилтийг хүлээн авч зарцуулдаг.

Тус хүрээлэнгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийг бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд нээж цалин хөлс, томилолт, ашиглалт, эд хогшил худалдан авахтай холбоотой зардал, хөрөнгө худалдан авах зэрэг Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байгаа мөн үндсэн орон тооны ажилтнуудад нэмэгдэл хөлс олгогдож байгаа асуудал нь холбогдох хууль, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг бодлогын хүрээнд бүх хүрээлэнгүүдийн хувьд анхаарах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудас/shilendans.gov.mn/-т нийт 118 гүйлгээний 5,076,268.1 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ байршуулсанаас 7 гүйлгээний 32,373.0 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь байрлуулаагүй, өмнөх оны зөрчлийг давтсанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас үндсэн орон тооны ажилтнуудад цалин олгосон нь Сангийн сайдын 2014 оны 55, 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т 210105 гэрээт ажлын хөлсийг бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын 2021 оны эхнийхагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 43,793.4 мянган төгрөгийн зөрчлөөс албан шаардлагын биелэлт 54.0 хувь, 43,793.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 98.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	0.0	1	0.0	1		87.6
Зөвлөмж	2	43,793,4	2	43,793,4			99.9
Нийт дүн	10	682,549.9	9	682,549.9	1		93.8

Шилэн дансны мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус хүрээлэнгийн гадаад болон дотоодын төслийн санхүүжилтийн орлого буюу нэмэлт санхүүжилтийн орлого 2022 онд нэмэгдэх төлөвтэй байгаа тул зарцуулалтыг холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,357,299.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 304,009.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 32,373.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,020,916.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулагдаагүй алдаа зөрчилгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3 дахь заалтын дагуу төсвийн тохируулгын тайлан бэлтгэж ирүүлээгүй.
- Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааны 52,059.0 мянган төгрөгийг авлагаар тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн гүйлгээний цэвэрлэх гүйлгээг зардлаар тайлагнасан.
- Нэмэлт санхүүжилтийн 251,950.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Одон орон, гео физикийн хүрээлэн	АХГ-2022/49 /НА-СТА-ТШЗ	Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3 дахь заалтын дагуу төсвийн тохируулгын тайлан бэлтгэж ирүүлээгүй	Залруулсан	1	0.0	1	0.0						
2	Одон орон, гео физикийн хүрээлэн	АХГ-2022/49 /НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааны 52,059.0 мянган төгрөгийг авлагаар, төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн гүйлгээний цэвэрлэх гүйлгээг зардлаар тайлагнасан.	Залруулсан	1	52,059.0	1	52,059.0						
3	Одон орон, гео физикийн хүрээлэн	АХГ-2022/49 /НА-СТА-ТШЗ	Нэмэлт санхүүжилтийн 251,950.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй	Залруулсан	1	251,950.7	1	251,950.7						
Санхүүгийн аудитаар					3	304,009.7	3	304,009.7						
4	Одон орон, гео физикийн хүрээлэн	АХГ-2022/49 /НА-СТА-ТШЗ	Шилэн данс цахим хуудаст 7 гүйлгээний 32,373.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	Өмнөх оны зөрчлийг давтсанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх	1	32,373.0					1	32,373.0		
5	Одон орон, гео физикийн хүрээлэн	АХГ-2022/49 /НА-СТА-ТШЗ	Бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас үндсэн орон тооны ажилтнуудад үндсэн цалингаас гадна 1,020,916.4 мянган төгрөгийн цалин олгосон байна.	Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллах	1	1,202,916.4							1	1,202,916.4
Нийцлийн аудитаар					2	1,053,289.4					1	32,373.0	1	1,202,916.4
Нийт дүн					5	1,357,299.1	3	304,009.7			1	32,373.0	1	1,202,916.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 19/АО160070

Улаанбаатар хот

АХГ-2022/49/НА-СТА-ТЦЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Одон орон, гоефизикийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Одон орон, гоефизикийн хүрээлэн нь 2021 онд нийт 5,076,268,067.91 төгрөгийн 118 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 32,373.019 төгрөгийн 17 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх аудитаар илэрсэн Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой зөрчлийг давтан гаргасан, аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаарын тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэснийг үндэслэн **ШААРДАХ** нь.

1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар албан шаардлага өгсөн зөрчлийг давтан гаргасан тул хариуцсан нягтлан бодогчид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал С.Дэмбэрэлд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-65.Docx

001080216

